



ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS
RESEARCH CENTER

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ



Банкуудын өрсөлдөөний тойм

1-р улирал,
2020



- ◇ Банкны салбарын мэдээ, мэдээлэл
- ◇ Үндсэн үзүүлэлтүүд
- ◇ Онцлох сэдэв: КОВИД-19 цар тахлын эсрэг
Монголбанкаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
- ◇ Арилжааны 13 банкны актив, зээл,
хадгаламж, ашгийн хэмжээ

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2020 он – I улирал

Банкны салбарын эргэн тойронд

01.01 – “ASIAMONEY” сэтгүүл нь 2017 оноос эхлээд Азийн орнуудын шилдэг банкуудыг 6 төрлийн номинацад шалгаруулсаар ирсэн бөгөөд өнгөрсөн 2019 онд Монгол Улсын Шилдэг банкаар Хаан Банк, Шилдэг ЖДҮ-ийг дэмжигч банкаар Трансбанк, Шилдэг Хувийн Банк болон Хөрөнгө Оруулагч банкаар ХХБ, Шилдэг Дижитал банкаар ЛэндМН, Шилдэг Нийгмийн Хариуцлагатай банкаар Ариг банк тус тус шалгарсан байна. transbank.mn

01.02 – ХААН банк орон даяар 100 киоск машин суурилуулж, банкны үйлчилгээг 24/7 болголоо. khanbank.com

01.07 – ХХБанк хиймэл оюун ухааны тусламжтайгаар харилцагчдынхаа төлбөр тооцоонд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалдаг боллоо. tdbm.mn

01.13 ХасБанк Нидерландын Хөгжлийн Агентлагаас 100 сая ам.долларын хамтын санхүүжилтийн эх үүсвэр авах гэрээнд гарын үсэг зурлаа. xacbank.mn

02.01 Хаан банк, ХХБ, Төрийн банк болон Трансбанк нар АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-ийн санхүүжилтээр Бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх “BEST” хөтөлбөрийг “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран хэрэгжүүлнэ. khanbank.com

02.03 – Голомт, Богд, Хаан, Төрийн банк, Капитрон зэрэг банкууд COVID-19 вирусийн эсрэг аянд нэгдэн ХӨСҮТ-д хандив өргөлөө. golomtbank.com

02.06 – Голомт банк эдийн засгийн хамтын ажиллагааны ОУ-ын банк (IBEC)-тай хамтран “ногоон төслүүд”-ийг санхүүжүүлэхээр боллоо. golomtbank.com

02.07 – Шинэчилсэн хамгаалалтын элемент бүхий мөнгөн тэмдэгтүүдийг гүйлгээнд гаргана. 2006 оны 20000 төгрөгийн дэвсгэртийг гүйлгээнээс татна. mongolbank.mn, MB

02.10 – Төрийн банкны олон улсын виза картын эзэмшигч та БНСУ-ын эрүүл мэндийн байгууллагуудад хөнгөлөлт эдлэх боломжтой боллоо. statebank.mn

02.17 – Голомт банк ОХУ-ын СБЕР банктай мэдээллийн технологи, дижитал банкны чиглэлээр хамтран ажиллана. golomtbank.com

03.01 – Трансбанк герман улсын Commerzbank-тай корреспондент дансны харилцаа тогтоолоо. transbank.mn

03.05 – ХААН банк SWIFT-ийн GPI системийг нэвтрүүлсэн Монголын анхны банк боллоо. khanbank.com


03.13 – COVID-19 вирус дэлхий нийтээр хурдтай тархаж, Пандемик (цар тахал)-ын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд Монгол банк өөрийн орны онцлогт тохирсон бодлогын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлээд байна. mongolbank.mn

03.20 – Монгол банк барьцаат зээлийн журамд 2020 оны 7 сарын 31-ний өдөр хүртэл түр хугацааны өөрчлөлт орууллаа. mongolbank.mn

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2020 он – I улирал

Банкны салбарын гол үзүүлэлтүүд¹



Нийт актив = 34,9 их наяд төгрөг

Банкны салбарын нийт актив 2020 оны 1-р улиралд 34,9 их наяд төгрөг болж өмнөх улирлаас 0,9 их наяд (-2,5%) төгрөгөөр буурсан бол өмнөх оны мөн үеэс 1,4 их наяд (+4%) төгрөгөөр өслөө.



Алдагдал = 27,7 тэрбум төгрөг

Банкуудын өөрийн хөрөнгө 2020 оны 1-р улирлын байдлаар 2,96 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0,39 их наяд төгрөгөөр буурчээ. Харин банкны салбарын ашиг 1-р улирлын байдлаар 27,7 тэрбум төгрөгийн алдагдалтай байна. Их хэмжээний алдагдал нь Ариг банкны алдагдлаас хамааралтай.



Банкны нөөц = 4,8 их наяд төгрөг

Банкны нөөц 2020 оны 1-р улирлын байдлаар 4,8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0,4 их наяд төгрөгөөр өсчээ. Харин өмнөх улиралтай харьцуулахад 1351 тэрбум төгрөгөөр буурсан байна.



Чанаргүй зээл 11,5%

Нийт дотоодын зээл (цэвэр) 2020 оны 1-р улирлын байдлаар 15.89 их наяд төгрөг болж буурав. Харин чанаргүй зээлийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна. 1-р улирлын байдлаар нийт чанаргүй зээл 1,822 их наяд төгрөг буюу нийт зээлийн (цэвэр) 11,5%-ийг эзэлж байна.

¹ Эх сурвалж: Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд, Монголбанк

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2020 он – I улирал


Ипотек = 4,64 их наяд төгрөг

Ипотекийн зээлийн үлдэгдэл 2020 оны 1-р улирлын байдлаар 4,64 их наяд төгрөг буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,2%-иар өссөн байна.




1 USD = 2769 MNT 1 CNY = 395 MNT

Монголбанкнаас зарласан ханшийн сарын дундаж хөдөлгөөнөөр 2020 оны 3-р сарын дундаж Ам.доллар-ын ханш 2769₮, Юань-ийн ханш 395₮ байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ам.долларын ханш 119₮-р (+5%), Юанийн ханш 5₮-р (+1,2%) тус тус өссөн байна.




Харилцах+Хадгаламж=18,6 их наяд ₮

2020 оны 1-р улирлын байдлаар банкны салбарын нийт хадгаламжийн хэмжээ 13,45 их наяд төгрөг, харилцах 5, их наяд төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж 10%-иар, харилцах 7%-иар өссөн байна.



Пассив = 32 их наяд төгрөг

2020 оны 1-р улирлын байдлаар банкны салбарын нийт пассив (өр төлбөр) 32 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1,8 их наяд (+6%) төгрөгөөр өсчээ.




Онцлох: КОВИД-19 цар тахлын эсрэг Монголбанкаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

2020 оны 3-р сарын 11-ний өдөр Мөнгөний бодлогын хорооноос санхүүгийн зуучлалыг дэмжих, банкуудын санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зорилгоор хэд хэдэн өөрчлөлтийг хийв.

1. Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах,
2. Төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг 2 нэгж хувиар бууруулж, 324 тэрбум төгрөгийн эх үүсвэр чөлөөлөх,
3. Бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +/-1 нэгж хувиар шинэчлэн тогтоох багц шийдвэр гаргах.
4. Банкны “Активыг ангилал, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д түр хугацааны өөрчлөлт оруулах. (2020 оны 1-р сарын 31-ний өдрөөс 2020 оны 7-р сарын 31-ний өдөр хүртэл)
 - “Хэвийн” зээлийн хувьд 15 хүртэлх хоног байсныг 90 хүртэлх хоног
 - “Анхаарал хандуулах” зээлийн ангиллыг 91-120 хоног,
 - “Чанаргүй” зээлийн ангиллыг 121-ээс дээш хоног байхаар тус тус тогтоож мөрдүүлж эхлэв.
5. Төв банкнаас арилжааны банкуудад олгох барьцаат зээлийн журамд өөрчлөлт оруулав. Ингэснээр банкууд барьцааны нөхцөл, шаардлагыг хангаснаар Монголбанкнаас 6 сарын хугацаатай (дахин 6 сараар сунгагдах боломжтой) эх үүсвэрийг 11 хувийн хүүтэй авч, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангах боломжийг бүрдүүлэв.

Дээрх өөрчлөлтүүд нь иргэд зээл авах хандлагийг өдөөх, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх гэх мэт цар тахлаас шалтгаалсан хямралын дарамтыг зөөллөх зорилготой.

Нийт шинээр олгосон зээлийн жинлэсэн дундаж хүү, %



БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2020 он – I улирал

Банкуудын өрсөлдөөн

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2020 оны 1-р улирлын байдлаар банкны салбарт нийт 13 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор банкны системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно. Үүнд:

- Актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Ашиг

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, бусад банкууд гэж ангилсан



АКТИВ

БАНКУУД

ТОМ-3 БАНК

>5 их наяд төгрөг

Худалдаа хөгжлийн банк
Хаан банк
Голомт банк

ДУНД-3 БАНК

1-5 их наяд төгрөг

Хасбанк
Төрийн банк
Улаанбаатар хотын банк

ЖИЖИГ БАНКУУД

<1 их наяд төгрөг

Чингис хаан банк
Капитрон банк
Үндэсний хөрөнгө оруулалтын банк
Ариг банк
Богд банк
Кредит банк
Тээвэр хөгжлийн банк


БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2020 он – I улирал




АКТИВ

Тайлант хугацаанд тайланд орсон 13 банкны нийт актив 34,9 их наяд төгрөг байна. Том-3 банк нийт активын 70,2%, Дунд-3 банк 18,7%, жижиг банкууд 6,9%-ийг эзэлж байна.

1 жилийн өмнөх мөн үетэй харьцуулахад том-3 банкны актив 8%, дунд-3 банкны актив 7%-иар өссөн бол жижиг банкуудын актив 10%-иар буурчээ.



Банкуудын активын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь




БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2020 он – I улирал




ЗЭЭЛ

Тайлант хугацаанд тайланд орсон 13 банкны нийт зээлийн үлдэгдэл 16,2 их наяд төгрөг байна. Үүнээс 66,5%-г Том-3 банк, 20%-г Дунд-3 банк 8,4%-г жижиг банкууд бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн хэмжээ Том-3 банк 1%, жижиг банкууд 5%-иар өссөн бол Дунд-3 банк 11%-иар буурсан байна. Харин нийт дүнгээр авч үзвэл банкуудын зээлийн хэмжээ сүүлийн нэг жилд 4,7%-иар буурчээ.




Зээлийн хэмжээ, тэрбум төгрөг болон өсөлтийн хувиар






ХАДГАЛАМЖ БА ХАРИЛЦАХ

Тайлант хугацаанд тайланд орсон нийт 13 банкны харилцах ба хадгаламжийн хэмжээ 19,2 их наяд төгрөг байна. Үүнээс 66%-г Том-3 банк, 22%-г Дунд-3 банк, 7,5%-г жижиг банкууд эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 6%-иар буурсан бол, Дунд-3 банк 13%-иар, жижиг банкууд 3%-иар тус бүр харилцах ба хадгаламжийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Нийт дүнгээр нь авч үзвэл харилцах болон хадгаламжийн хэмжээ 10%-иар өсчээ.






Хадгаламж ба харилцахын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлт



АШИГ

2020 оны 1-р улирлын байдлаар тайланд орсон 13 арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд нийт 51,8 тэрбум төгрөгийн ашигтай (татварын өмнөх дүн) ажиллажээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банкны ашиг 56%-иар буюу 45 тэрбум төгрөгөөр буурч 36 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Дунд-3 банкны ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2%-иар буурч 12.8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Харин жижиг банкуудын хувьд 3.3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ.

Банкуудын ашиг, алдагдал (тэрбум төгрөгөөр):



Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень 1Y'20, Монголбанк
2. Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд 1Y'20, Монголбанк
3. Монголбанкны ханшийн сарын дундаж хөдөлгөөн, Монголбанк
4. Арилжааны банкуудын улирлын санхүүгийн тайлан 1Y'20
5. Арилжааны банкуудын зээлийн тайлан, 2020 оны 3-р сар